



БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар ____

Номгон

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйлжиллагааг сайжруулахад зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлтийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2024 оын 03 дугаар сарын 01-ний өдрийн “Бууцагаан сумын төсөвт байгууллагуудад албаны нэрэмжит, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх тухай” №2024/01 тоот удирдамжийн дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс ажлын 2 хоног зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, илэрсэн зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Эрх зүйн чадамжтай шийдвэр гаргах, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь “Хууль бус захиргааны акт гэж эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг ойлгоно”, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх “утга агуулгын илэрхий алдаатай”, 47.1.6 дахь “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

2. Эдийн засгийн ангилалын дагуу хөрөнгө мөнгийг захиран зарцуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах.

3. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллах (дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан томилж томилох, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, тусгайлсан төлөвлөгөө, удирдамж боловсруулах, хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлэх), Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

642312124

4. Урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжтой төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахгүй байх Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

5. Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахгүй байх, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.1 дэх “Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна” гэснийг хэрэгжүүлэх.

6. Тооллогын комиссын гишүүд ажлын үр дүнг сайжруулж хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, ашиглахгүй байгаа хөрөнгийн ашиглалтын тогтоож, өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулан, үлдэх өртөггүй дахин ашиглах боломжгүй хөрөнгийн жагсаалт гаргах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.2-т “тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих”, 72.4.3-т “агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах”, 72.4.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, 72.4.5-т “эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

7. Хөрөнгө хариуцсан албан хаагч солигдох тухай бүр тооллого хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

8. Автомашинд худалдан авсан сэлбэг, хэрэгслийг тухай бүр бүртгэлд тусган, хувийн хэрэгт тэмдэглэж баримтжуулах, сэлбэгийн эвдрэлийг тогтоохдоо өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг гаргуулж байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ”, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, 31.3 дахь “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараахь журмыг баримтална”, 31.3.1 дэх “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

9. Нийтлэг үйлчилгээний оператор, Биеийн тамирын арга зүйчийг албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 1.2 дахь “”Албан тушаалын тодорхойлолт” гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын тусгай шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг ойлгоно”, 1.3 дахь “Албан тушаалын тодорхойлолт нь төрийн албан хаагч тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хариуцах үндэслэл болно”, 5.1 дэх “Албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээд шийдвэр гаргаж, албан тушаал тус бүрээр батална” гэснийг хэрэгжүүлэх.

10. Цалингийн урьдчилгаа хувь хэмжээ хэтрүүлэн олгож байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2 дахь “Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгал нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хассан цалин хөлсний дүнгийн 20 хувиас, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эсхүл хэд хэдэн суутгал зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байгаа тул зөрчлийг арилгаж ажиллах.

11. Мэдээллийн ил тод байдлын хангаж, шилэн дансны порталл сайтад мэдээллийг хугацаанд нь иж бүрэн үнэн зөв мэдээлж Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

12. Шатахуун зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас хөтлөх, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.4-т жолоочийн тооцооны хуудас”, “Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр нь түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана” гэснийг хэрэгжүүлэх.

13. Няравын тайланг бүрэн хөтлөх, Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 2.10-т “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна” гэснийг хэрэгжүүлэх.

Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах, хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор албан бичгээр ирүүлэх.

ЗӨВЛӨМЖ ӨГСӨН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Д.МӨНХХАНД

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
ТӨСӨВ ТӨРИЙН САНГИЙН
МЭРГЭЖИЛТЭН
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
НЯРАВ

Л.БҮРНЭЭБААТАР
Б.ЗӨЛЗАЯА

Г.ЭНХТҮВШИН
А.ОТГОНЦЭЦЭГ
М.ЖАРГАЛСАЙХАН

